



ᠮᠣᠨᠭᠦ, ᠰᠠᠨᠬᠡᠭᠦᠭᠢᠶᠢᠨ
ᠰᠠᠯᠪᠠᠷᠢᠨ ᠰᠤᠲᠤᠳᠢᠰᠲᠢᠬᠤ
ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ

МӨНГӨ, САНХҮҮГИЙН САЛБАРЫН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ





АГУУЛГА

- I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ
- II. МЭДЭЭЛЛИЙН АЧ ХОЛБОГДОЛ
- III. ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ ТҮҮНИЙГ ТООЦОХ АРГА ЗҮЙ
- IV. МЭДЭЭЛЛИЙН ТАРХААЛТ



МОНГОЛЫН
УЛСЫН
СТАТИСТИКА



ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН:

- МУ-ын “Статистикийн тухай хууль”

АРГАЧЛАЛ:

- Мөнгө, зээл, үнэт цаасны статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал

АНГИЛАЛ:

- ISIC 4.0 (сар, жил, улирлын мэдээ)
- CPC 2.0

I. МӨНГӨ, САНХҮҮГИЙН СТАТИСТИКИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ



Мөнгө, санхүү
K 64-66

**Мөнгө,
санхүү
K 64-66**

64 – Даатгалын болон тэтгэврийн санхүүжилтийн үйл ажиллагаанаас бусад санхүүгийн үйлчилгээний үйл ажиллагаа

Санхүүгийн зуучлал, Төв банкны үйл ажиллагаа, Мөнгөний зуучлал, Холдинг компаний үйл ажиллагаа, Итгэлцэл, сангийн үйл ажиллагаа, Лизингийн үйл ажиллагаа, Зээл олгох үйлчилгээ

65 – Албан журмын нийгмийн даатгалаас бусад даатгал, давхар даатгал, тэтгэврийн санхүүжилтын үйл ажиллагаа

Амьдралын болон амьдралын бус даатгалын үйл ажиллагаа, Давхар даатгалын үйл ажиллагаа, Тэтгэврийн сангийн үйл ажиллагаа

66 – Санхүүгийн бусад үйл ажиллагаа

Санхүүгийн зах зээлийн удирдлага, Үнэт цаас, брокерийн үйл ажиллагаа, Эрсдэл, хохирлын үнэлгээ, даатгалын төлөөлөгч, зуучлагч, Хөрөнгө оруулалтын сангийн удирдлагын үйл ажиллагаа

I. МӨНГӨ, САНХҮҮГИЙН СТАТИСТИКИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ



Мөнгө, санхүүгийн салбарын мэдээг - дамжуулах, боловсруулах, тархаах хугацаа





МӨНГӨ, САНХҮҮГИЙН САЛБАРЫН МЭДЭЭНИЙ МАЯГТ:

Маягтын тоо:


- Албан ёсны 2 маягт
- Захиргааны 10 маягт

Албан ёсны мэдээ цуглуулдаг маягтын үзүүлэлтийн тоо:

- **БЗҮ-1а** Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааны 20... оны ...-р улирлын мэдээ
- **ААНБ-1, 2** Аж ахуйн нэгж, байгууллагын 201... оны үйл ажиллагааны дэлгэрэнгүй (хураангуй) мэдээ



МӨНГӨ, САНХҮҮГИЙН СТАТИСТИКТ ДАРААХ ЗАХИРГААНЫ МЭДЭЭЛЛИЙГ ЦУГЛУУЛДАГ



МОНГОЛЫН СТАТИСТИК



СТАТИСТИКИЙН ХЭРЭГЛЭЭ, АЧ ХОЛБОГДОЛ

1. САЛБАРЫН НИЙТ МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ, ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХЭМЖЭЭГ ТООЦОХ (Биет хэмжээ, үнийн дүнгээр)
2. САЛБАРЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ, ГАРСАН ӨӨРЧЛӨЛТИЙГ ТОДОРХОЙЛОХ (Улсын түвшинд, эдийн засгийн салбарын ангиллаар)
3. САЛБАРЫН ТӨЛӨВ БАЙДЛЫГ ХАРЬЦУУЛАХ ЧИГ ХАНДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ (Дэлхийн, бүсийн нутгийн, улс орнуудын түвшинд)

СТАТИСТИКИЙН АШИГЛАЛТ

1. СТАТИСТИКИЙН САРЫН БЮЛЛЕТЕНЬ, ТАНИЛЦУУЛГА ГАРГАХ (улирал, жилээр)
2. СТАТИСТИКИЙН ЭМХЭТГЭЛ (жилээр)
3. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТООЦООНД (улирал, жилээр)
4. НӨӨЦ АШИГЛАЛТЫН ХҮСНЭГТ, САЛБАР ХООРОНДЫН ТЭНЦЛИЙН ТООЦООНД (жилээр)
5. СТАТИСТИКИЙН БУСАД ТӨСӨЛ, СУДАЛГААНД
6. СТАТИСТИКИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙГ ТУЛГАЖ, ШАЛГАХАД



ИРГЭДИЙН ХЭРЭГЛЭЭ, АЧ ХОЛБОГДОЛ:

1. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГААНЫ АЖИЛ
2. БИЗНЕСИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
3. НИЙГЭМД ЧИГЛЭСЭН СУДАЛГАА
4. СУРГАЛТ СУРТАЛЧИЛГАА

ᠠᠨᠠᠭᠤ ᠰᠤᠳᠠᠯᠭᠠᠨ ᠠᠵᠢᠯ



АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ХЭРЭГЛЭЭ, АЧ ХОЛБОГДОЛ:

1. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГААНЫ АЖИЛ
2. БИЗНЕСИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
3. ӨРСӨЛДӨХ ЧАДВАРАА СУДЛАХ
4. ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА
5. БАЙГУУЛЛАГУУДЫН УДИРДЛАГААС АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ БОДЛОГЫГ ЗӨВ ТОДОРХОЙЛОХ,
САНХҮҮГИЙН БОЛОН БУСАД НӨӨЦИЙГ ОНОВЧТОЙ ХУВААРИЛАХ



ТӨР, ЗАСГИЙН ХЭРЭГЛЭЭ, АЧ ХОЛБОГДОЛ:

1. САЛБАРЫН БОДЛОГО БОЛОВСРУУЛАХ
2. УЛС ОРНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫГ СУДЛАХ
3. ТӨР, ЗАСГААС АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ БОДЛОГЫГ ЗӨВ ТОДОРХОЙЛОХ, САНХҮҮГИЙН БОЛОН БУСАД НӨӨЦИЙГ ОНОВЧТОЙ ХУВААРИЛАХ
4. ӨНӨӨГИЙН ХҮРСЭН ТҮВШИНЭЭ ҮНЭЛЭХ, ХЭТИЙН ТӨЛӨВИЙГ ТООЦООЛОХ;



III. ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД ТҮҮНИЙГ ХЭРХЭН ТООЦОХ АРГА ЗҮЙ



- 1. Мөнгөний нийлүүлэлт.** (M2) нь хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө, төгрөгийн болон валютын харилцах (M1), цэвэршүүлсэн алтны харилцах, төгрөг болон валютын хадгаламж, хадгаламжийн сертификатын (Quasi money) нийлбэр юм.
- 2. Бага мөнгө.** (M1) Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө болон төгрөгийн харилцах дансан дахь мөнгөний нийлбэрээр тодорхойлно.
- 3. Бараг мөнгө.** Төгрөгийн болон гадаад валютын хадгаламж, валютын харилцах, цэвэршүүлсэн алтны харилцах, хадгаламжийн сертификатын нийлбэрээр тооцно.

ᠮᠣᠩᠭᠦᠨᠢᠨᠢᠯᠡᠭᠡᠯᠡᠲᠦ

III. ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД ТҮҮНИЙГ ХЭРХЭН ТООЦОХ АРГА ЗҮЙ



4. Зээл. Зээлийн өрийн үлдэгдлийг улсын байгууллага, хувийн хэвшил, иргэд, бусад санхүүгийн бус байгууллага, санхүүгийн бусад байгууллага гэсэн ангиллаар, мөн арилжааны банкаар, нийт дүнгээр нь мэдээлнэ. Иргэд, байгууллагад олгосон зээлийн үлдэгдлийг зээлийн чанар буюу хугацааны үзүүлэлтээр хэвийн, хугацаа хэтэрсэн, чанаргүй зээл гэж ангилна.

5. Хадгаламж. Тогтмол нэрлэсэн үнэтэй, төлбөр хийхэд ашиглагддаг санхүүгийн хөрөнгө юм. Энэ нь хүүгийн орлого олж болох солилцооны шууд хэрэгсэл, эсхүл хадгаламж эзэмшигчдээ тусгайлсан үйлчилгээгээр үйлчлүүлэх эрхийг олгож болно.

6. Валютын ханш. Үндэсний мөнгөн тэмдэгтийн бусад орны мөнгөн тэмдэгттэй харьцуулсан үнэ юм.



ᠮᠤᠩᠭᠡᠨ
ᠰᠠᠨᠬᠡᠭᠦᠨ
ᠰᠠᠨᠬᠡᠭᠦᠨ
ᠰᠠᠨᠬᠡᠭᠦᠨ



7. Өрийн бичиг /Бонд/. Тодорхой хугацааны дараа үндсэн төлбөр болон хүүг мөнгөн, эсхүл тодорхой эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн хэлбэрээр эргүүлэн төлөх үүргийг гэрчилсэн үнэт цаасыг ойлгоно.

8. Үнэт цаас. Засгийн газар болон бусад эрх бүхий этгээдээс гаргасан өрийн бичиг /бонд/, компанийн бүх төрлийн хувьцаа, компанийн гаргасан, эсхүл гаргахаар санал болгож буй хувьцааг худалдах, худалдан авах эрхийн бичиг /опцион/, хөрөнгө оруулалтын сангийн хувьцааг ойлгоно.

9. Хувьцаа. Компанид хөрөнгө оруулж, түүнийг үндэслэн хувь нийлүүлэгчдийн хуралд оролцож санал өгөх, ногдол ашиг авах, компанийг татан буулгасны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдан борлуулснаас олсон орлогоос хувь хүртэх болон хуулиар тогтоосон бусад эрхийг гэрчилсэн үнэт цаасыг ойлгоно.



САРД ТАРХААДАГ ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД:

1. МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ, сарын эцэст
2. БАНКУУДЫН НЭГДСЭН ТАЙЛАН ТЭНЦЭЛ, сарын эцэст
3. ВАЛЮТЫН ЗАХ ЗЭЭЛИЙН НЭРЛЭСЭН ХАНШ, сарын дундаж
4. АЖ АХУЙН НЭГЖ, ИРГЭДЭД ОЛГОСОН ЗЭЭЛИЙН ӨРИЙН ҮЛДЭГДЭЛ, зээлийн ангиллаар, сарын эцэст
5. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ, сарын эцэст
6. ИДЭВХТЭЙ АРИЛЖСАН ҮНЭТ ЦААС
7. ХАНШ НЬ ХАМГИЙН ИХ ӨССӨН ҮНЭТ ЦААС
8. ХАНШ НЬ ХАМГИЙН ИХ БУУРСАН ҮНЭТ ЦААС




ЖИЛД ТАРХААДАГ ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД:

1. МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ
2. ИРГЭДИЙН ХАДГАЛАМЖИЙН ҮЛДЭГДЭЛ, бүс, аймаг, нийслэлээр
3. ЗЭЭЛИЙН ӨРИЙН ҮЛДЭГДЭЛ, бүс, аймаг, нийслэлээр
4. ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ӨРИЙН ҮЛДЭГДЭЛ, бүс, аймаг, нийслэлээр
5. ВАЛЮТЫН ХАНШ
6. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ
7. ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ ХАМГИЙН ӨНДӨР БАЙСАН 30 КОМПАНИ
8. ҮНЭТ ЦААС НЬ ИДЭВХТЭЙ АРИЛЖИГДСАН 30 КОМПАНИ
9. ХУВЬЦААНЫ АРИЛЖААНЫ ҮЗҮҮЛЭТ
10. КОМПАНИЙ БОНДЫН АРИЛЖАА, арилжаа хийгдсэн оноор
11. ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА
12. ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, оны эцэст
13. БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, оны эцэст
14. ХАДГАЛАМЖ ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, оны эцэст



1212

- Хэвлэлийн бага хурал
- Сарын бюллетень, товхимол, статистикийн ном
- Цахим хэлбэр - web site
<http://www.1212.mn//> , iPad, Iphone
- Мэдээллийн үйлчилгээний төв
- Статистикийн лавлах утас 1212



Хэвлэмэл бүтээгдэхүү



Хэрэглэгчийн хүсэлтээр



Интернет



ᠮᠣᠩᠭᠡᠯᠡᠯᠡᠭᠡᠨ ᠰᠤᠲᠢᠰᠲᠢᠬᠢ
 National Statistics



СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН

[НЭВТРЭХ](#) | [МЭДЛЭГЭЭ ШАЛГАЯ](#) | [АШИГЛАХ ЗААВАР](#) | [ХОЛБОО БАРИХ](#) | [EN](#)

- [СТАТИСТИК](#)
- [ФАЙЛЫН САН](#)
- [ГАЗАРЗҮЙН МЭДЭЭЛЛИЙН САН](#)
- [ДЭД МЭДЭЭЛЛИЙН САН](#)
- [ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО](#)
- [СОНИРХОЛТОЙ СТАТИСТИК](#)



Тээвэр

Тээврийн салбар нь өргөн уудам нутагтай, хүн ам харьцангуй сийрэг суурьшилтай манай улсын хувьд эдийн засагт чухал ач холбогдолтой салбарын нэг юм. Манай улсад авто, төмөр зам, агаар, усан замын үндсэн 4 төрлийн тээврийн дэд салбарууд үйл ажиллагаа явуулж байна. Авто тээврийн статистикийн мэдээллийг аж ахуйн нэгж, байгууллагууд аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газраар дамжуулан, агаарын болон төмөр замын тээврийн мэдээг иргэний агаарын тээврийн компаниуд, Иргэний нисэхийн ерөнхий газар болон Төмөр замын хэрэг эрхлэх газар шууд Үндэсний статистикийн хороонд ирүүлж байна.

ТАНИЛЦУУЛГА

ХҮСНЭГТ

ГАЗРЫН ЗУРАГ

хайх хүснэгтийн нэрээ бичнэ үү

ХАЙХ

Бүлэг	Хүснэгтийн нэр
Тээвэр	БҮХ ТӨРЛИЙН ТЭЭВРИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ
Тээвэр	АВТО ЗАМЫН ТЭЭВРИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ
Тээвэр	ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ
Тээвэр	АГААРЫН ТЭЭВРИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ
Тээвэр	ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГТ ХАМРАГДСАН АВТО МАШИНЫ ТОО, төрлөөр, сумаар
Тээвэр	ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГТ ХАМРАГДСАН АВТО МАШИНЫ ТОО, насжилтаар, сумаар



ᠠᠨᠬᠠᠠᠷᠠᠯ
ᠬᠠᠨᠳᠤᠭᠤᠯᠤᠰᠠᠨᠳ
ᠪᠠᠶᠠᠷᠯᠠᠯᠠᠭᠠ

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА